

“I-CREATE” СЭДЭВТ УРАЛДААНЫ УДИРДАМЖ

Улаанбаатар, хот

2019.11.11

Нэг. Үндэслэл:

Дэлхийн эрүүл эндийн байгууллагаас гаргасан судалгаар дэлхийн нийт хүн амын 15% нь ямар нэгэн төрлийн хөгжлийн бэрхшээлтэй ба 2-4% нь өдөр тутмын амьдралаа авч явах чадваргүй байнгын асаргаанд амьдарч байна.

Монгол улсын үндэсний статистикийн хорооны 2018 онд гаргасан судалгаагаар манай улсад 105,730 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байгаагаас:

- харааны 11,524
- хэл ярианы бэрхшээлтэй 4,314
- сонсголын бэрхшээлтэй 8,639
- оюун ухааны бэрхшээлтэй 20,371
- хөдөлгөөний 21,608
- хавсарсан 7,280
- бусад төрлийн 32,194 байна.

Даяарчлагдаж буй 21-р зууны дэвшилтэт техник технологи, мэдээлэл, харилцаа холбооны хөгжилд тулгуурлан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ хүртэх, сурч боловсрох, хөгжих, хөдөлмөр эрхлэх, бие даан амьдрах эрхийг хангах, нийгмийн оролцоог баталгаажуулах үүднээс тэдний онцлог хэрэгцээнд тохирсон түгээмэл загвар бүхий тохирох хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж, бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгон нэвтрүүлэх хэрэгтэй байна.

Хоёр. Зорилго

Оюутан залуусын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, нийгэмдээ хувь нэмрээ оруулах идэвхтэй иргэн болгон төлөвшүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх, тэдэнд тулгамдаж буй асуудлуудыг судалж, ойлгох, шийдлийг эрэлхийлэх, өнөө цагийн нийгэмд хэрэгтэй техник технологийн шинэлэг бүтээлийг бий болгох зорилготой.

Гурав: Тавигдах шаардлага

Хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээнд зориулсан тохируулах хэрэглэгдэхүүн агуулгын хувьд:

- Баррейль компьютерийн гар (Харааны бэрхшээлтэй хүнд зориулсан компьютерийн гар)
- Аудио программ (Харааны бэрхшээлтэй хүнд зориулсан текстен мэдээллийг аудио хэлбэр лүү хөрвүүдэг тусгай программ)
- Sesame phone (Гараа хөдөлгөх боломжгүй эсвэл хязгаарлагдмал бэрхшээлтэй хүмүүст зориулсан мэдрэгчгүй утас)
- Wheelmap (Тэргэнцэртэй иргэдэд зориулсан Хүртээмжтэй барилга байгууламжийн талаарх мэдээлэл бүхий апплейкейшн)
- Автомат тэргэнцэр (Тулгуур эрхтний бэрхшээлтэй болон амхад настнуудад зориулсан автомат тохиргоотой тэргэнцэр)
- Хиймэл эрхтэн

Ирүүлэх бүтээлд тавигдах шаардлага:

- Хүний өдөр тутмын амьдралдаа хийдэг анхан шатны үйлдлүүд (хоол идэх, усанд орох, бие засах гэх мэт)-ийг хийхэд дэмжлэг үзүүлсэн, хөнгөвчлсэн тоног төхөөрөмж, туслах хэрэгсэл, бүтээгдэхүүн үйлчилгээ байх;
- Ирүүлсэн бүтээл нь хэрэгжих боломжтой, онол арга зүйн үндэслэлтэй байх;
- Хамгийн бага тохируулга шаардсан бүтээгдэхүүн, программ хангамж байх;
- Өртгийн хувьд хямд байх;
- Хөдөлгөөн хөнгөвчлөх хэрэгсэл, тоног төхөөрөмж болон туслах технологи, ялангуяа шинэ технологи, тусламж үзүүлэх бусад хэлбэр, нэмэлт үйлчилгээ болон объектын талаархи мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй хүртээмжтэй болгосон байх;
- Олон улсад хэрэгжсэн шилдэг бүтээлийг нутагшуулах хэлбэр, шийдэлтэй байж болно.

Гурав. Зохион байгуулалт

1. Уралдааны зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим хуудас, зурагт самбруудаар тараах, түгээх, сурталчлах;
2. Хөгжлийн бэрхшээл, тохиорх хэрэглэгдэхүүн, түгээмэл загварын талаар ойлголт, мэдээлэл өгөх нөлөөллийн сургалтыг 2020 оны 1 дүгээр улиралд шат дараалалтайгаар Их дээд сургуулиудад зохион байгуулах;
3. Уралдааны бүтээлийг 2020 оны 06 сарын 01 хүртэл хүлээн Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын Тамгын газарт хүлээн авна.
4. Шалгарсан бүтээлийг техник, технологийг хөгжүүлэгч аж ахуйн нэгжүүдтэй танилцуулан цаашид үйлдвэрлэн нэвтрүүлэх;

Дөрөв. Хамрах хүрээ

- Их дээд сургуулиудын-ийн оюутан, залуус,
- Эрдэмтэн судлаачид

Тав: Шагналын сан

Нэгдүгээр байр- Өргөмжлөл, 3.000.000 төгрөг, бүтээгдэхүүн үйлчилгээг үйлдвэрлэх, хэрэгжүүлэх эрх, олон улсын туслах хэрэгсэл, тохиорх хэрэглэгдэхүүний үзэсгэлэнд оролцох эрх

Хоёрдугаар байр- Өргөмжлөл, 2.000.000 төгрөг, бүтээгдэхүүн үйлчилгээг үйлдвэрлэх, хэрэгжүүлэх эрх

Гуравдугаар байр- Өргөмжлөл, 1.000.000 төгрөг, бүтээгдэхүүн үйлчилгээг үйлдвэрлэх, хэрэгжүүлэх эрх

“ХҮРТЭЭМЖТЭЙ ИРЭЭДҮЙ”